



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,  
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2019.10.27 № 07/9114  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Худалдан авах ажиллагааг  
зохион байгуулах тухай


Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах, агаар, ус, орчны бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн арга хэмжээний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах "Майдар хот төсөл" хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажлын 650,0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын даалгаврыг боловсруулан хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллана уу.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тендерийн үнэлгээний хороонд тус яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмарыг ажиллуулахыг мэдэгдье.


Хавсралт 1. Засгийн Газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн 390 дугаар тогтоолын хуулбар..... хуудас

Хавсралт 2. Майдар хотын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын даалгавар 9 хуудас.



Н.ЦЭРЭНБАТ

БАТЛАВ:

БОАЖА-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  **ЦЭЦЭНГЭЛ**

2019 оны дүгээр сарын -ны өдөр

**ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат: “Майдар хот”-ын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажил

<p><b>1. Ажлын даалгавар өгөх үндэслэл:</b></p>	<p>1.Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө; 2.Нийслэл хотыг 2020-2030 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл, 3.МУ-ын ЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах;</p>
<p><b>2. Ажлын зорилго, гарах үр дүн:</b></p>	<p>-Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах,агаар, хөрс, ус, орчны бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх; -“Майдар хот” төсөл хэрэгжихэд шаардагдах хүн амын унд ахуйн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэж, найдвартай эх үүсвэрээр хангах; -Нийслэл хотыг хөгжүүлэх хөгжлийн стратеги төлөвлөгөө /2020-2030 он/, хэтийн төлөвлөлттэй уялдуулан ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж усны нөөцийг тогтоох; -Хүн амын есөн нэмэгдэх хэрэглээ, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлт, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, зэрэг бусад усны найдвартай хэрэглээг хангах; -Ус хангамжийн зориулалтаар гидрогеологийн эрэл-хайгуулын ажлыг одоогийн мөрдөгдөж байгаа арга зүй, аргачлалын дагуу явуулж, газрын доорх усны хуримтлал үүссэн, ус хангамжийн хэтийн төлвийг хангах боломжит талбайг сонгосон байна. -Хүн амын ус хангамжийн хэрэгцээг хангаж чадахуйц газрын доорх усны эх үүсвэрийг илрүүлэн тогтоож, усны ашиглалтын нөөц баялгийг үйлдвэрлэлийн зохих зэргээр үнэлж тодорхойлон олборлолтонд бэлтгэнэ. -Усны чанар найрлага нь хүн амын унд ахуйн усан хангамжид ашиглах боломжтой эсэхэд дүгнэлт гаргана. -Усны эх үүсвэр тогтоосон талбайд газрын доорх усны горимын ажиглалтын 1 цооног ерөмдөж, мониторингийн сүлжээнд хамруулахаар тоноглож бэлтгэнэ. - Ирээдүйн ус авах байгууламжийн бүдүүвчийг оновчтой хувилбараар сонгож, түүний ашиглалтын үйл ажиллагааны горимийн талаар мэргэжлийн заавар зөвлөмж өгнө. -Усны нөөцийг хомсдох бохирдохоос хамгаалах, үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх</p>

	<p>үүсвэрт энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн заагийг тогтооно.</p> <p>-Унд ахуйн эх үүсвэрийн эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэм мөрдөх талаарх зөвлөмж гаргана.</p> <p>3. Судалгааны ажлын хөтөлбөр</p> <p>Гидрогеологийн эрэл хайгуулын судалгааны ажлын хүрээнд зайлшгүй болон нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлууд:</p> <p>-Геологи-гидрогеологийн талбайн маршрут, ажиглалт, уст цэгийн бүртгэл, тосллого;</p> <p>-Талбайн геофизикийн,цооногын каротажийн хэмжилт судалгаа;</p> <p>-Гидрогеологийн өрөмдлөг;</p> <p>-Шавхалт,туршилтын ажлууд;</p> <p>-Гидрохимийн дээжлэлт;</p> <p>-Горимын ажиглалт;</p> <p>-Лабораторийн шинжилгээ;</p> <p>-Топо-геодезийн ажил;</p> <p>-Суурин боловсруулалт гэх мэт.</p>
<p>4. Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал</p>	<p><u>Хээрийн ажлын бэлтгэл:</u></p> <p>-Газрын доорх усны эрэл-хайгуулын ажлыг явуулах төсөл, төсөв зохиох, техник хэрэгсэл, хүн хүчийг бэлтгэх;</p> <p>-Тухайн бүс нутгийн хэмжээнд өмнө хийгдсэн ижил төстэй геологи-гидрогеологийн судалгааны материалтай нэг бүрчлэн танилцаж, зохих боловсруулалт хийж, цаашид явуулах судалгааны ажлын аргагүй аргачлалыг нарийвчлан боловсруулах;</p> <p>- “Майдар хот”-ын хүн амын усан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэхийн тулд агаар сансарын зураг ашиглан, хэрэглэгчдэд хамгийн ойр, усны есөн нэмэгдэх хэрэгцээг хангах газрын доорх усны хуримтлал бүхий талбайг сонгож дүн шинжилгээ хийх.</p> <p>- <u>Хээрийн судалгааны үе:</u></p> <p>- Эрэл-хайгуулын судалгааны талбайн хүрээнд геологи-гидрогеологийн маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэлийг хийж, геоморфологи, структур-тектоникийн байдал геологийн тогтоц, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлтэй газар дээр нь нарийвчлан танилцах;</p> <p>- Газрын гадаргуугийн орчин үеийн хотгор, гүдгэрийн дүрс зүйн холбогдох хэмжилт, шаардлагатай бичиглэл, баримтжуулалтыг хийх;</p> <p>- Анхан шатны мэдээлэл, баримтыг цуглуулан, агаар сансарын зурагт тайлал, боловсруулалтыг хийж гидрогеологийн эрлийн шалгуур, шинж тэмдгийг илрүүлэн цаашдын судалгаандаа ашиглах;</p> <p>- Геофизикийн талбайн судалгааг зохих арга аргачлалын дагуу явуулж, газрын доорх усны байгалийн нөөцийн хуримтлал, бөөгнөрөл байж болох тодорхой цэг, усжсан бүсийг тогтоох;</p> <p>-Судалгааны талбайн геологийн тогтоц, гидрогеологийн нөхцлийг иж бүрэн үнэлж ус хэрэглэгчид хамгийн ойр байх өндөр усжилттай, газрын доорх усны хуримтлал бүхий талбайг сонгон шинээр өрөмдөх цооногуудын байршлыг төлөвлөх;</p> <p>-Усан хангамжийн зориулалттайгаар ашиглах инженерийн хийцтэй цооногуудыг технологийн дагуу өрөмдөх, тоноглох.</p>

	<p>- Шавхалтын ажлыг түвшний бууралт, сэргэлтийн хэмжилтийн өгөгдлүүдийг автомат болон цахилгаан түвшин хэмжигч багажаар хэмжих,</p> <p>-Гидрогеологийн ерөмдлөг, шавхалт туршилтын болон гидрохимийн дээжлэлтийн ажлыг зохих арга зүй, аргачлалын дагуу гүйцэтгэж, гарсан үр үнд онолын тайлал, боловсруулалтын ажлыг хийх;</p> <p>- Эрэл-хайгуулын гидрогеологийн судалгаа явуулж буй талбайд тархсан газрын доорх усны гидрохимийн дээжинд лабораторын холбогдох шинжилгээг хийж, түүний чанар, химийн найрлагад MNS 900:2018 жишгийн дагуу мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгөх, -Усны эх үүсвэр болгон ашиглах талбайд газрын доорх усны хяналт шинжилгээ хийх шаардлагад нийцсэн горимын ажиглалтын цооног бэлтгэж, сав газрын захиргаанд актаар хүлээлгэн өгөх</p> <p>-Гидрогеологийн ерөмдлөг, шавхалт-туршилт хийгдсэн талбайн нөхөн сэргээлтийг хийж, сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, акт үйлдэх;</p> <p>-Хайгуулын ажлын үр дүнд тогтоосон өндөр усжилттай цооногийг ашиглалтанд бэлтгэн тоноглох;</p> <p>-Хээрийн хайгуулын ажлын үед өрөмдлөгийн журнал болон шавхалт туршилтын ажлын анхдагч хээрийн материалуудыг Усны нөөцийн хэлтэст хүлээлгэн өгөх гэх мэт.</p> <p><b>Суурин боловсруулалтын үе:</b></p> <p>- Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланг БОНХАЖС-ын 2015 оны А-173 дугаар тушаалаар батлагдсан "Газрын доорх усны нөөцийг хүлээн авах ангилал, зэрэглэл"-ийн аргачилсан зааврын дагуу боловсруулж, БОАЖЯ-ны усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.</p>
<p><b>5. Судалгааны ажлын байршил:</b></p>	<p>Хуучин Налайх хотын цөвөр усны эх үүсвэрээр ашиглаж байсан талбай. Хайгуул хийх талбай 11,8 км<sup>2</sup>  107°19'13.41" 47°48'19.58" 107°16'57.87" 47° 48'18.448"  107°16'38.99" 47°49'6.81" 107°16'41.06" 47° 50°13.79"  107° 19'30.89" 47° 50"11.47"</p>
<p><b>6. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:</b></p>	<p>Засгийн газрын нөөц сангаас</p>
<p><b>7. Захиалагч байгууллага</b></p>	<p>МУ-ын Засгийн газар</p>

<p><b>8. Ажил гүйцэтгэх хугацаа:</b></p>	<p>Эхлэх хугацаа : 2019 оны 12 -р сарын 20  Дуусах эцсийн хугацаа: 2020 оны 9-р сарын 15  /тайланг хүлээлгэн өгөх хугацаагаар тооцов. /  Газрын доорх усны нөөц тооцсон үр дүнгийн тайланг Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх</p>
<p><b>9.Мөрдөх хууль тогтоомж, стандарт,</b></p>	<p>- Усны тухай хууль  -Төсвийн тухай хууль  -Өрөмдлөгийн ажлын стандарт</p>

	-БОНХАЖСайдын 2015 оны А-17Здугаар тушаал/Усны эрэл хайгуул хийх ажлын аргачлал/
10. Тавигдах шаардлага, тусгай нөхцөл	-Хээрийн ажлын явц, гүйцэтгэл, арга аргачлалыг хянах зориулалтаар 1-2 удаа хөндлөнгийн хяналт хийх зардлыг гүйцэтгэгч хариуцана.

"Майдар хот"-ын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын даалгаврыг:


Хянасан:

Боловсруулсан:

БОАХЯ. ГЗБУНБЗГ -ын дарга

 / Ш.Мягмар/

УНХ-ийн ахлах мэргэжилтэн

 / Д.Өнөржаргал/

УНХ-ийн даргын албан үүргийг  
Түр орлон гүйцэтгэгч ..... / Ч.Мөнхзул/

Майдар хотын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажил

## ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

### Нэг. Ажлын зорилго

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэрэгжиж буй Үндэсний бүтээн байгуулалт Их Майдар бүрхэний сэрэг дүр болон түүнийг хүрээлэн бий болох танин мэдэхүй, түүх, соёл, урлагийн аялал жуулчлалын цогцолбор нь байгалийн хамгийн үзэсгэлэнт газрын нэг болох Богд Хан уулын өвөрт байрлах бөгөөд 2012 онд энэхүү газрыг Европын холбооны хот төлөвлөлтийн багтай хамтран сонгон авч орчин үеийн шинэ хотыг хөгжүүлэх ажлыг эхлүүлсэн.

Майдар хотын ус хангамжийн хэрэглээгээр төлөвлөгдөж байгаа хүн амын тоо 280000 болно. Цаашид хүн амын есөн нэмэгдэх усны хэрэглээг хангах шаардлага гарна. Газрын доорх усны нөөц тогтоох эрэл-хайгуулын ажлыг гүйцэтгэн усны нөөцийг үйлдвэрлэлийн зохих зэргээр үнэлэх, хотын хүн амыг унд ахуйн найдвартай эх үүсвэрээр хангах зорилготой.

### Хоёр. Хийгдэх ажил, хүрэх үр дүн

1. Газрын доорх усны эрэл-хайгуулын үе шатны гидрогеологийн судалгааны ажлыг гүйцэтгэн ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг мөн усны чанарын хувьд хэрэглээг бүрэн хангахуйц газрын доорх усны эх үүсвэрийг тогтоох;
2. Усны чанар, химийн найрлагад лабораторын шинжилгээ хийлгэж, хүн амын унд-ахуйн хэрэглээнд ашиглаж болох эсэхэд мэргэжлийн дүгнэлт өгөх;
3. Судалгаанд хамрагдсан талбайн хүрээнд ус авах байгууламжийн бүдүүвчийн оновчтой хувилбарыг сонгож, түүний ашиглалтын үйл ажиллагаа болон горимын талаар мэргэжлийн заавар, зөвлөмж боловсруулах; газрын доорх усны нөөц бусад уул уурхайн үйл ажиллагаанаас хамааран нөлөөлөлд орж байгаа эсэхийг тодорхойлох
4. Газрын доорхи усны түвшний болон чанар найрлагын еөрчлөлтийг хянах мониторингийн ажиглалтын 1 цооног бэлтгэн хүлээлгэн өгөх;

Гурав. Газрын доорх усны эрэл- хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга зүй, аргачлал болон ажлын дэс дараалал

### 3.1. Бэлтгэл үе

3.1.1 Эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны төсөлд хамрагдаж буй бүс нутгийн дэвсгэр талбайн хэмжээнд урьд өмнө гүйцэтгэсэн холбогдох судалгааны баримтат материал, түүний үр дүнтэй нарийвчлан танилцаж, шаардлагатай баримт мэдээллийг бүрдүүлж нэгтгэн, эмхтгэх, тухайн судалгааны ажлын аргачлалыг онол, арга зүйн хувьд оновчтой сонгох

3.1.2 Судалгааны ажлын төсөл, төсөв зохиож боловсруулах

3.1.3 Өрөмдлөгийн болон шавхалт туршилт хийх техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх, үйлдвэрлэлийн ажилд бэлтгэх, ажиллагсадын хөдөлмөр хамгаалал, ахуйн нөхцлийг хангах, инженер-техникийн ажилтаны зохих бүрэлдэхүүнтэй газрын доорх усны хайгуулын ажлыг бие даан удирдаж хийж чадварлаг гидрогеологчдын багийг бүрдүүлэх

### 3.2. Хээрийн ажлын үе

3.2.1 Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгаанд хамрагдаж буй тухайн бүс нутгийн хэмжээнд геологи-гидрогеологийн маршрут, ажиглалтыг явуулж, уст цэгийн бүртгэл, тооллого хийх, геоморфологи, тектоник-структур болон геологи-гидрогеологийн үндсэн суурь нөхцлийн талаар анхан шатны тулгуур мэдээлэл, баримт материалыг бүрдүүлж, агаар, сансрын зургийн холбогдох тайллыг хийх;

3.2.2 Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны төсөлд хамрагдаж буй бүс нутгийн дэвсгэр талбайн хэмжээнд гадаргуугийн болон зайнаас тандан судлах геофизикийн судалгаа явуулж, гүний бүтцийг нарийвчлах сөвсгэр хурдас болон түүний доогуур шургаж тогтсон үндсэн суурь чулуулагийн дээд хил зааг структурыг ялгах;

3.2.3 Маршрут болон геофизикийн судалгааны ажлын үр дүнд тулгуурлан тодорхой цэгүүд дээр гидрогеологийн өрөмдлөгийн ажлыг дэс дараалсан системээр гүйцэтгэх, хурдас чулуулагийн геологийн зүсэлт, литологийн бүрэлдэхүүний онцлог, усжилтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч өндөр усжилттай уст үе, давхрагуудыг ялгаж тогтоох, гидрогеологийн сорилт туршилтын ажил, өрөмдлөгийн ажлыг зохих арга зүй аргачлалын дагуу гүйцэтгэх, уст үе давхрагын гидрогеологийн тооцооны үндсэн параметрийг тодорхойлох, хээрийн ажлын анхан шатны баримтжуулалтыг зохих журмын дагуу хийх;

3.2.4 Гидрогеологийн өрөмдлөгийн ажлын хүрээнд шүүрийн янданг 168 мм-ээс дээш диаметртэй хийх бөгөөд шавхалт туршилтын ажлыг эрлифтийн аргаар 72 цагаас дээш хугацаанд бууралт сэргэлтийг хэмжсэн хэмжилтүүдийг үндэслэн тооцоонд авсан байна.

3.2.5 Газрын доорхи усны чанар, химийн найрлагын шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториудад хийлгэж MNS 900:2005 жишгийн үзүүлэлттэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх;

3.2.6 Судалгааны талбайн хэмжээнд өрөмдөгдсөн бүх цооног, бусад төрлийн уст цэг, түүнчилэн байгалийн болон техноген гаралтай тулгуур объектуудын байршлыг зохих хураангуйлалттай байр зүйн зурагт буулгаж, топогеодезийн хэмжилтийг хийж, холбогдох боловсруулалтыг хийх;


3.2.7 Судалгаанд хамрагдсан талбайн хүрээнд газрын доорх усны горимын ажиглалт, хэмжилт явуулж, түүнчлэн нарийвчилсан хайгуулын ажлын хүрээнд зохих гидрогеологийн арга зүй аргачлалын хувьд тухайн талбайд ашиглаж байгаа хугдгуудын байдал, газрын доорхи усны горимын ажиглалтын хэмжилтүүдийг хийж үнэлэлт дүгнэлт харьцуулалт хийж, газрын доорх усны түвшний болон чанар, найрлагын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийг судлан тогтоох, холбогдох үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ашиглагдахаар төлөвлөж байгаа талбайд горимыг судлах зорилгоор газрын доорх усны мониторингийн ажиглалт хийх хяналт хэмжилтийн 1 цооногийг хяналт хэмжилт хийхээр өрөмдөж тоноглон сав газрын захиргаанд тус тус актаар хүлээлгэн өгөх;

## Дөрөв. Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүн


- 4.1 Газрын доорх усны хайгуулын ажил хийх талбайд явуулах эрэл-хайгуулын ажлын үр дүнд хотын хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар газрын доорх усны ордын ашиглалтын нөөцийг үнэлж тодорхойлох гидрогеологийн иж бүрэн судалгааны ажил гүйцэтгэж усны хэрэглээг усны нөөц, чанарын хувьд бүрэн хангахуйц газрын доорх усны эх үүсвэрийг тогтоох, тухайн хэсгийн газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн зохих зэргээр үнэлэх, газрын доорх усны чанар, химийн найрлагын шинжилгээг хийлгэж, үнэлэлт дүгнэлт өгөх;
  - 4.2 Гидрогеологийн эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланд газрын доорх усны нөөцийг шавхалт туршилтын хэмжилтүүдийн үзүүлэлтэд тулгуурлан тоон аргаар болон газрын доорх усны программ хангамж ашигласан бодолтуудыг хийж загварчлалын түвшинд үр дүнг гаргах;
  - 4.3 Эрэл-хайгуулын судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан болон холбогдох хавсралт, зураг, схем, хүснэгт, зурмаг материалыг БОНХАЖС-ны 2015 оны А-173 тушаалын дагуу боловсруулах;
  - 4.4 Судалгаанд хамрагдсан талбайн хүрээнд үйлдвэрлэлийн зохих зэргээр үнэлж тогтоосон газрын доорх усны ашиглалтын нөөцийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж, баталгаажуулах.
- Тав . Ажил гүйцэтгэх хугацаа**
- 5.1 Төсөл, төсөв боловсруулж баталгаажуулах: 2019 оны *K*-р сар
  - 5.2 Хээрийн ажил: 2019 оны *1L* дугаар сар
  - 5.3 Суурин боловсруулалтын ажил: 2019 оны *J*-р сар
  - 5.4 Газрын доорхи усны эрэл хайгуулын ажлын үр дүн, түүний тайланг боловсруулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэх




Майдар хотын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажил явуулах талбай



# Майдар хотын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажил явуулах талбай





# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 390

Улаанбаатар  
хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-26.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах, агаар, хөрс, ус, орчны бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн арга хэмжээний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах 602.6 (зургаан зуун хоёр сая зургаан зуун мянган) сая төгрөг, "Майдар хот төсөл" хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны хайгуул, судалгааны ажил болон төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах 783.8 (долоон зуун наян гурван сая найман зуун мянган) сая төгрөг, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийхэд зарцуулах 167.0 (нэг зуун жаран долсон) сая төгрөгийн зардлыг тус тус гүйцэтгэлийг нь хянасны үндсэн дээр Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР

Барилга, хот байгуулалтын сайд

Х.БАДЕЛХАН

*А. Оюу Аюулдар*  
*Х/19.*